



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр
цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/153/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
(Дорноговь аймаг, Сайншанд сум)
2020 он

Тэргүүлэх аудитор:	Ч.Ариунаа
Утас: 70522734	Цахим хаяг:
Аудитын менежер:	Э.Энхцэцэг
Утас: 70523020	Цахим хаяг:
Аудитор:	Г.Энхтөр
Утас: 99032916	Цахим хаяг:

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1 Аудитын гэрчилгээ	3
2 Аудитын тайлан.....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	8
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.10.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	10
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12. Шилэн дансны мэдээлэл	10
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3 Менежментийн захидал.....	12
4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	14

1 Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.26 № 1-6/284

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД
СУМЫН ХҮҮХДИЙН 4 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Н.СҮХТОГОО ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар өр, авлагагүй ажиллах зөвлөмж өгсөн боловч 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 3,359.8 мянган төгрөгийн авлагатай бөгөөд үүнээс 2018 оны 2,302.6 мянган төгрөгийн авлагыг шийдвэрлээгүй байна.

2018 онд үүссэн 2,302.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар төлбөрийн акт тогтоосон боловч төлбөрийн актыг барагдуулаагүй байна.


Энэ нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байхаас гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 заалтыг зөрчсөн байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч Н.Сүхтогод танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 19-өөс 2020 оны 2 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захиалгаар Ингүүмэл жаргалант аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн

аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг нь “Багш бүр хичээл, сургалтын бэлтгэлийг чанартай ханган, үр дүнтэй хэрэгжүүлж, багш, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж, суралцагчийн хөгжил, төлөвшилд ахиц гаргах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Байгууллагын үүсгэн байгуулах баримт бичигт зааснаар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа.

Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- ХХОАТ-ын тухай хууль

Тайлан хугацаанд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 33 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн дагуу ажил гүйлгээг санхүүжүүлж байгаа тул материаллаг байдлын сууриар нийт зардлыг сонгосонтой холбоотой юм.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2019 оны нийт зардал 456,247.48 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 912.49 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь нэг удаагийн ажил гүйлгээний дүнг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 655.10 мянган төгрөгөөр буюу 0.05 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	7,325.90	3,359.80	(3,966.10)
Урьдчилгаа			-
Бараа материал	75,633.40	98,584.70	22,951.30
Үндсэн хөрөнгө	1,112,570.20	1,092,929.90	(19,640.30)
Нийт хөрөнгө	1,195,529.50	1,194,874.40	(655.10)
Өр төлбөр	221.20		(221.20)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,195,308.30	1,194,874.40	(433.90)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,195,529.50	1,194,874.40	(655.10)

Бараа материалын дансны үлдэгдэл өсөхөд 2020 оны 1 дүгээр сард хэрэглэхээр 2019 оны 12 дугаар сард 7,356.07 мянган төгрөгийн мах худалдан авсан мөн 9,400.00 мянган төгрөгийн хүүхдийн тоглоом худалдан авсан, эцэг эхчүүдийн хандиваар 6,020.97 мянган төгрөгийн тоглоом хүлээн авсан нь нөлөөлж байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд 440,583.90 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 436,146.60 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 2,244.08 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардал 2,115.65 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	3,359.78	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	3	3,359.78	

2.10.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. 2019 оны 12 дугаар сарын 17-нд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-с 302.50 мянган төгрөгийн үнэ бүхий нярвын программ авч нярав бараа материалын орлого, зарлагын гүйлгээ хийхэд ашиглаж байгаа бөгөөд тайлант хугацааны бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн зардалд тооцсоныг аудитын явцад залруулж биет бус хөрөнгөөр ангилж бүртгэсэн.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглалтанд байгаа хөрөнгийн талаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар өр, авлагагүй ажиллах зөвлөмж өгсөн боловч 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 3,359.78 мянган төгрөгийн авлагатай бөгөөд үүнээс 2018 оны 2,302.55 мянган төгрөгийн авлагыг шийдвэрлээгүй байна.
2. Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн, өөрчлөлтийг бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-н маягтаар үнийн дүнгээр тайлагнасан байна.
3. Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан заавар, маягтын дагуу үнэн зөв хөтөлдөггүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн

3.1.1 Илрүүлэлт:

2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар өр, авлагагүй ажиллах зөвлөмж өгсөн боловч 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 3,359.78 мянган төгрөгийн авлагатай бөгөөд үүнээс 2018 оны 2,302.55 мянган төгрөгийн авлагыг шийдвэрлээгүй байна.

Энэ нь эрх ба үүрэг, бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийн тухай хууль зөрчих, авлагыг барагдуулаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 заалт, 39 дүгээр зүйлийн 39.4.2 заалтуудыг мөрдөж ажиллана. Мөн авлагатай холбоотой баримтыг бүрдүүлэн харьяалах шүүхийн байгууллагад хөөн хэлэлцэх хугацаанд багтаан нэхэмжлэл гарган авлагыг барагдуулах нь зүйтэй.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

3.2.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн, өөрчлөлтийг бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-н маягтаар үнийн дүнгээр тайлагнасан байна.

Энэ нь үнэн зөв байх, бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн, өөрчлөлтийг анхан шатны баримтгүйгээр тайлагнах.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Хариуцсан нягтлан бодогч Сангийн сайдын 2018 оны 100 тоот тушаалаар баталсан үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл /ҮХ-1/-г хөтлөхдөө Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан анхан шатны баримт болох ҮХ-1, ҮХ-2, ҮХ-3, ҮХ-4 маягтуудыг үндэслэх бөгөөд дээрх бүртгэл, маягтуудыг холбогдох санхүүгийн баримтын хамт хадгална. Иймд Сангийн сайдын баталсан дээрх заавар маягтуудыг судлан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

3.3 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.3.1 Илрүүлэлт:

Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан заавар, маягтын дагуу үнэн зөв хөтөлдөггүй байна.

Энэ нь үнэн зөв байх, бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалыг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Хууль журмын хэрэгжилтийг хангаагүй байх, ээлжийн амралтын тооцоо илүү, дутуу тооцогдох.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан заавар, маягтын дагуу цэцэрлэгийн эрхлэгч хариуцан үнэн зөв хөтлөх бөгөөд нягтлан бодогч уг мэдэгдлийг үндэслэн ээлжийн амралтын тооцоо, олговрыг бодож холбогдох санхүүгийн баримтын хамт хадгална.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

5 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

БАЛАНСЫН ЗҮЙЛ		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	82,959,315.49	101,944,551.21
27	АВЛАГА	7,325,900.09	3,359,780.71
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	3,703,160.38	985,776.00
29	Төлбөртэй үйлчилгээний авлага	249,566.00	-
34	Бусад авлага	3,373,173.71	2,374,004.71
35	Байгууллагаас авах авлага	2,340,252.91	2,302,552.91
36	Хувь хүмүүсээс авах авлага	1,032,920.80	71,451.80
60	БАРАА МАТЕРИАЛ	75,633,415.40	98,584,770.50
61	Түүхий эд материал	3,992,000.00	19,862,956.00
62	Тусгай зориулалттай материал	3,992,000.00	19,862,956.00
66	Хангамжийн материал	71,641,415.40	78,721,814.50
67	Бичиг хэргийн материал	374,500.00	626,500.00
68	Аж ахуйн материал	64,583,776.50	65,383,776.50
70	Түлш шатах тослох материал	188.00	-
72	Хүнсний материал	6,682,950.90	12,711,538.00
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,112,570,182.20	1,092,929,890.43
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,112,570,182.20	1,092,929,890.43
108	Биет хөрөнгө	1,078,470,182.20	1,058,642,890.39
109	Барилга, байгууламж	1,046,638,970.00	1,052,227,970.00
110	Хуримтлагдсан элэгдэл	-	(22,240,723.92)
113	Машин, тоног төхөөрөмж	42,956,590.00	52,389,390.00
114	Хуримтлагдсан элэгдэл	(27,063,151.12)	(33,791,148.57)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,100,853.00	33,760,653.00
116	Хуримтлагдсан элэгдэл	(17,163,079.68)	(23,783,250.12)
125	Номын фонд	-	80,000.00
126	Биет бус хөрөнгө	34,100,000.00	34,287,000.04
127	Програм хангамж	440,000.00	715,000.00
128	Хасагдуулга	-	(87,999.96)
129	Бусад биет бус хөрөнгө	33,660,000.00	33,660,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,195,529,497.69	1,194,874,441.64
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	221,234.20	-
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	221,234.20	-
164	Өглөг	221,234.20	-
166	Бараа үйлчилгээний зардлын өглөг	221,234.20	-
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,195,308,263.49	1,194,874,441.64
215	Засгийн газрын хувь оролцоо	1,195,308,263.49	1,194,874,441.64
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	33,660,000.00	33,660,000.00
217	Өмч: -Төрийн өмч	33,660,000.00	33,660,000.00
223	Хуримтлагдсан үр дүн	1,161,648,263.49	1,161,214,441.64
224	Өмнөх үеийн үр дүн	1,161,648,263.49	1,161,648,263.49
225	Тайлант үеийн үр дүн	-	(433,821.85)
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,195,529,497.69	1,194,874,441.64

4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

Үзүүлэлт		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	443,684,590.00	452,723,856.00
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	56,290,690.00	12,139,956.00
77	Нийтлэг татварын бус орлого	56,290,690.00	5,669,000.00
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	56,290,690.00	5,669,000.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	56,290,690.00	5,669,000.00
99	Тусламжийн орлого	-	6,470,956.00
100	Хандив тусламж /дотоод/	-	6,470,956.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	387,393,900.00	440,583,900.00
112	Улсын төвлөрсөн төсвөөс	384,304,100.00	377,008,000.00
113	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	384,304,100.00	377,008,000.00
122	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,089,800.00	
126	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	3,089,800.00	
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	63,575,900.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	63,575,900.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	423,439,360.20	453,157,677.85
148	УРСГАЛ ЗАРДАЛ	423,439,360.20	453,157,677.85
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	415,234,319.20	448,614,976.04
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	202,941,757.55	249,333,007.42
151	Цалин	198,886,066.55	249,237,015.42
152	Нэмэгдэл цалин	2,066,600.00	95,992.00
154	Урамшуулал	1,989,091.00	-
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,145,936.59	31,052,987.87
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	16,801,189.56	21,236,456.60
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,912,103.32	2,504,866.27
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,856,233.23	2,003,893.03
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	691,664.81	482,524.75
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,884,745.67	4,825,247.22
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,521,834.20	61,129,042.08
165	Гэрэл цахилгааны зардал	5,928,445.00	7,159,620.90
166	Түлш, халаалтын зардал	52,837,130.20	47,064,238.00
167	Цэвэр, бохир усны зардал	7,756,259.00	6,905,183.18
170	Хангамж, бараа материалын зардал	1,862,691.70	2,851,264.00
171	Бичиг хэргийн материал	163,900.00	579,500.00
172	Тээвэр, шатахууны зардал	199,861.70	200,188.00
173	Шуудан холбоо интернетийн төлбөр	70,000.00	91,540.00
174	Ном, хэвлэлийн зардал	27,930.00	86,500.00
175	Хог хаягдал устгах, цэвэрлэх	-	893,566.00
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	1,401,000.00	999,970.00
181	Нормативт зардал	68,379,385.10	66,561,982.90
182	Эм	98,600.00	98,600.00
183	Хоол	67,830,785.10	66,463,382.90

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450,000.00	-
185	Эд хогшил, урсгал засварын зардал	-	264,700.00
186	Багаж хэрэгсэл	-	9,700.00
189	Урсгал засвар	-	255,000.00
190	Томилолт, зочны зардал	90,000.00	485,200.00
192	Дотоод томилолтын зардал	90,000.00	485,200.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	360,000.00	1,055,000.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	360,000.00	855,000.00
196	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	200,000.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	49,932,714.06	35,881,791.77
211	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,135,200.00	204,900.00
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,797,514.06	35,676,891.77
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,205,041.00	4,542,701.81
228	Бусад урсгал шилжүүлэг	6,465,300.00	100,000.00
231	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	100,000.00
234	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,814,600.00	-
235	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,650,700.00	-
237	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,739,741.00	4,442,701.81
240	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,739,741.00	4,442,701.81
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	20,245,229.80	(433,821.85)
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	225,654,504.45	-
283	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	225,654,504.45	-
287	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(225,654,504.45)	-
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(205,409,274.65)	(433,821.85)

4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

ҮЗҮҮЛЭЛТ		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	384,304,100.00	443,673,700.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	384,304,100.00	443,673,700.00
111	Улсын төвлөрсөн төсвөөс	384,304,100.00	377,008,000.00
112	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	384,304,100.00	377,008,000.00
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,089,800.00
125	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	-	3,089,800.00
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	63,575,900.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	63,575,900.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	384,304,100.00	433,581,100.00
148	УРСГАЛ ЗАРДАЛ	384,304,100.00	433,581,100.00
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	376,099,059.00	429,038,398.19
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	201,120,765.00	249,546,221.91
151	Үндсэн цалин	179,506,397.00	181,924,225.14
152	Нэмэгдэл	7,874,870.00	35,311,898.77
154	Үр дүнгийн урамшуулал	13,739,498.00	32,310,098.00
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	24,497,400.00	31,449,000.00
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	16,663,900.00	20,765,300.00
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,717,900.00	2,023,800.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,807,200.00	2,529,800.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	391,600.00	505,900.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,916,800.00	5,624,200.00
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	66,300,600.00	61,205,253.28
165	Гэрэл цахилгааны зардал	5,618,606.00	6,214,634.90
166	Түлш, халаалтын зардал	53,078,794.00	47,353,800.00
167	Цэвэр, бохир усны зардал	7,603,200.00	7,636,818.38
170	Хангамж, бараа материалын зардал	2,257,396.00	2,236,010.00
171	Бичиг хэрэг	463,600.00	153,000.00
172	Тээвэр, шатахуун	200,000.00	200,000.00
173	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	91,540.00
174	Ном, хэвлэл	27,930.00	147,500.00
175	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	249,566.00	644,000.00
176	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,246,300.00	999,970.00
181	Нормативт зардал	80,031,898.00	72,279,613.00
182	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	98,600.00	98,600.00
183	Хоол, хүнс	69,283,498.00	71,431,013.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,649,800.00	750,000.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	-	9,664,700.00
186	Багаж техник хэрэгсэл	-	9,409,700.00
189	Урсгал засвар	-	255,000.00
190	Томилолт, зочны зардал	90,000.00	485,200.00
192	Дотоод албан томилолт	90,000.00	485,200.00

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	400,000.00	1,300,000.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	400,000.00	1,100,000.00
196	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	200,000.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	1,401,000.00	872,400.00
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	1,401,000.00	872,400.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,205,041.00	4,542,701.81
225	Бусад урсгал шилжүүлэг	6,465,300.00	100,000.00
228	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	100,000.00
231	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,814,600.00	-
232	Хөдөө орон нутагт тогвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,650,700.00	-
234	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,739,741.00	4,442,701.81
237	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,739,741.00	4,442,701.81
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	10,092,600.00
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	10,092,600.00
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	10,092,600.00
263	Дотоод эх үүсвэрээр	-	10,092,600.00
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	10,092,600.00
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(10,092,600.00)
279	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2	2018 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	-	-	1,367,057,538.14	1,367,057,538.14
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,367,057,538.14	1,367,057,538.14
5	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн				
6	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз				
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	33,660,000.00	-	(205,409,274.65)	(171,749,274.65)
9	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	33,660,000.00	-	1,161,648,263.49	1,195,308,263.49
10	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	33,660,000.00	-	1,161,648,263.49	1,195,308,263.49
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,660,000.00	-	1,161,648,263.49	1,195,308,263.49
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			(433,821.85)	(433,821.85)
18	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	33,660,000.00		1,161,214,441.64	1,194,874,441.64

4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

ЗАРДЛЫН ЗҮЙЛ		ТАЙЛАНТ ОНЫ		ЗӨРҮҮ	
	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	440,583,900.00	436,146,598.19	4,437,301.81	98.99
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	440,583,900.00	436,146,598.19	4,437,301.81	98.99
4	Бараа, үйлчилгээний зардал	440,483,900.00	436,046,598.19	4,437,301.81	98.99
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	251,790,300.00	249,546,221.91	2,244,078.09	99.11
6	Үндсэн цалин	183,001,300.00	181,924,225.14	1,077,074.86	99.41
7	Нэмэгдэл	35,311,900.00	35,311,898.77	1.23	100.00
9	Урамшуулал	33,477,100.00	32,310,098.00	1,167,002.00	96.51
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,449,000.00	31,449,000.00	-	100.00
12	Тэтгэврийн даатгал	20,765,300.00	20,765,300.00	-	100.00
13	Тэтгэмжийн даатгал	2,023,800.00	2,023,800.00	-	100.00
14	ҮОМШӨ ний даатгал	2,529,800.00	2,529,800.00	-	100.00
15	Ажилгүйдлийн даатгал	505,900.00	505,900.00	-	100.00
16	Эрүүл мэндийн даатгал	5,624,200.00	5,624,200.00	-	100.00
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,320,900.00	61,205,253.28	2,115,646.72	96.66
18	Гэрэл цахилгаан	7,603,600.00	6,214,634.90	1,388,965.10	81.73
19	Түлш, халаалт	47,353,800.00	47,353,800.00	-	100.00
20	Цэвэр, бохир ус	8,363,500.00	7,636,818.38	726,681.62	91.31
22	Хангамж, бараа материалын зардал	8,846,000.00	8,836,010.00	9,990.00	99.89
23	Бичиг хэрэг	100,000.00	153,000.00	(53,000.00)	153.00
24	Тээвэр (шатахуун)	250,000.00	200,000.00	50,000.00	80.00
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	66,000.00	91,540.00	(25,540.00)	138.70
26	Ном, хэвлэл	130,000.00	147,500.00	(17,500.00)	113.46
27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	644,000.00	56,000.00	92.00
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	7,600,000.00	7,599,970.00	30.00	100.00
30	Нормативт зардал	72,332,700.00	72,279,613.00	53,087.00	99.93
31	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	98,800.00	98,600.00	200.00	99.80
32	Хоол, хүнс	71,483,900.00	71,431,013.00	52,887.00	99.93
33	Нормын хувцас зөөлөн эдлэл	750,000.00	750,000.00	-	100.00
34	Эд хогшил худалдан авах	9,655,000.00	9,655,000.00	-	100.00
35	Багаж, техник, хэрэгсэл	9,400,000.00	9,400,000.00	-	100.00
38	Урсгал засвар	255,000.00	255,000.00	-	100.00
39	Томилолт, зочны зардал	490,000.00	485,200.00	4,800.00	99.02
41	Дотоод албан томилолт	490,000.00	485,200.00	4,800.00	99.02
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,300,000.00	1,300,000.00	-	100.00
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,100,000.00	1,100,000.00	-	100.00

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	200,000.00	200,000.00	-	100.00
53	Бараа үйлчилгээний бусад зардал	1,300,000.00	1,290,300.00	9,700.00	99.25
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300,000.00	1,290,300.00	9,700.00	99.25
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,000.00	100,000.00	-	100.00
70	Бусад урсгал шилжүүлэг	100,000.00	100,000.00	-	100.00
73	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	100,000.00	100,000.00	-	100.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	440,583,900.00	440,583,900.00	-	100.00
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	377,008,000.00	377,008,000.00	-	100.00
99	Улсын төсвөөс санхүүжих	377,008,000.00	377,008,000.00	-	100.00
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	63,575,900.00	63,575,900.00	-	100.00
104	Орон нутгийн төсвөөс	63,575,900.00	63,575,900.00	-	100.00
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	24.00	24.00	-	100.00
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	-	100.00
136	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.00
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
148	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-

4.6. Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

	ЗАРДЛЫН ЗҮЙЛ	ТАЙЛАНТ ОНЫ		ЗӨРҮҮ	
		ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	ҮЗҮҮЛЭЛТ				
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,089,800.00	3,084,400.00	5,400.00	99.60
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	3,089,800.00	3,084,400.00	5,400.00	99.60
4	Бараа, үйлчилгээний зардал	3,089,800.00	3,084,400.00	5,400.00	99.60
34	Эд хогшил худалдан авах	3,089,800.00	3,084,400.00	5,400.00	99.60
35	Багаж, техник, хэрэгсэл	3,089,800.00	3,084,400.00	5,400.00	99.60
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,089,800.00	3,089,800.00	-	100.00
120	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,089,800.00	3,089,800.00	-	100.00
124	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,089,800.00	3,089,800.00	-	100.00
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	24.00	24.00	-	100.00
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	-	100.00
136	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.00
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
148	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-